

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-149-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Нисэх клубийн гэрчилгээжүүлэлт (Шинэчлэгдэж байгаа) /15 хуудас/ 2016 оны amend.2</p>	<p align="center">НИСЭХ КЛУБ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) / 6 хуудас (үндсэн дүрэм- 11 хуудастай байсан)/ 1997 оны NZ orijinal</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>149.1. Хамрах хүрээ Энэ Дүрэм нь хэт хөнгөн агаарын хөлгөөр сургалт зохион байгуулах нисэх клубийн гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно</p>	<p>149.1. Зорилго (а) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Нисэх клубыг гэрчилгээжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны журмыг тогтооход энэ дүрмийн зорилго оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>149.3. Гэрчилгээний шаардлага Энэ Дүрмийн дагуу олгосон Нисэх клубийн гэрчилгээнд зааснаас бусад тохиолдолд, нисэх клуб нь ИНД-ээр гэрчилгээ эсхүл зэрэглэлтэй байхыг шаардсан этгээдэд нисэхийн баримт бичиг олгохтой холбоотой ажиллагааг зохион байгуулахгүй:</p>	<p>149.3. Нисэх клубын гэрчилгээ (а) Аливаа этгээд нь дараах гэрчилгээг эзэмшсэний үндсэн дээр Нисэх клубын үйл ажиллагаа явуулна: 1/ энэ дүрмийн дагуу олгосон нисэх клубын гэрчилгээ; эсвэл 2/ ИНД-103–ын дагуу олгосон <u>хэт хөнгөн агаарын хөлгийн</u> үйл ажиллагааны гэрчилгээ</p>	<p>-Нисэхийн баримт бичиг олгох эрхийг орхигдуулсан</p>
<p>149.5. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах Нисэх клубийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА0149/01 маягтыг бөглөж дараах баримт бичгийн хамт Даргад хүргүүлнэ: (1)149.65-д шаардсан Ерөнхий заавар; (2)зохих төлбөрийн баримт.</p>	<p>149.5. Өргөдөл гаргах (а) Энэ дүрмийн дагуу нисэх клубын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч /цаашид Өргөдөл гаргагч гэх/ нь ИНЕГ-0149/01 маягтыг бөглөж дараах бичиг баримтыг хавсарган ИНЕГ-т ирүүлнэ: 1/ энэ дүрмийн 149.65-д заасан <u>Үйл ажиллагааны заавар</u>; <u>2/ нисэх клубын удирдах ажилтнуудын дэлгэрэнгүй танилцуулга</u>; 3/ төлбөрийн баримт.</p>	<p>-Exposition-үйл ажиллагааны заавар гэснийг ерөнхий заавар болгосон</p>
<p>149.7. Гэрчилгээ олгох Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь нисэх клубийн гэрчилгээ эзэмших эрхтэй: (1)149.51(а)(1) - (2) болон (3)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүн байх; (2)хүсэлт гаргагч нь В Бүлгийн шаардлагыг хангасан; (3)тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.</p>	<p>149.7. Гэрчилгээ олгох (а) <u>ИНЕГ</u> нь, энэ дүрмийн 149.5-т заасны дагуу ирүүлсэн материалыг судалсны үндсэн дээр, Өргөдөл гаргагчийг энэ дүрмийн шаардлагыг бүрэн хангасан, нисэх клубын үйл ажиллагаа нь нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй гэж үзвэл гэрчилгээг олгоно.</p>	<p>-орхигдуулсан заалтыг оруулсан</p>
<p>149.9. Гэрчилгээ эзэмшигчийн эрх Нисэх клубийн гэрчилгээ эзэмшигч нь дараах эрхийг хэрэгжүүлж болно: (1)Даргын шилжүүлсэн эрх эзэмшиж байгаа удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь аливаа этгээдэд тухайн байгууллагын гэрчилгээнд заасан гэрчилгээ болон зэрэглэл олгох ажлыг зохион байгуулах; (2)тухайн эрхийг гэрчилгээнд заасан тохиолдолд, ИНД-91-ийн дагуу нисэх спортын арга хэмжээг зохион байгуулах; (3)тухайн эрхийг гэрчилгээнд заасан тохиолдолд, ИНД-</p>	<p>149.9. Гэрчилгээ эзэмшигчийн эрх (а) Нисэх клубын гэрчилгээ эзэмшигч дараах эрхтэй: 1/ <u>нисэх спортын зэрэглэл олгох</u>; 2/ гэрчилгээнд заагдсан эрхийн дагуу, ИНД-91-ийн хүрээнд нисэх спортын арга хэмжээ, үзүүлбэр, шоу зохион байгуулах; 3/ тусгайлан олгогдсон бусад эрх.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

<p>149-ийн байгууллага хэрэгжүүлэхийг ИНД-ээр шаардсан бусад эрх.</p>		
<p>149.11. Гэрчилгээний хугацаа (a) Нисэх клубийн <u>гэрчилгээг 5 жил</u> хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно. (b) Нисэх клубийн гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, эсхүл түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна. (c) Нисэх клубийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон бол гэрчилгээг Даргад хураалгана. (d) Нисэх клубийн гэрчилгээг түдгэлзүүлсэн бол, эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг <u>Даргад</u> хүргүүлнэ.</p>	<p>149.11. Гэрчилгээний хугацаа (a) Нисэх клубын <u>гэрчилгээг 3 жил</u> хүртэл хугацаагаар олгоно. (b) Нисэх клубын гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дуусах, эсхүл ИНЕГ-аас нисэх клубын үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох хүртэл хүчинтэй байна. (b) ИНЕГ-аас нисэх клубын гэрчилгээг хүчингүй болгосон, эсхүл үйл ажиллагааг нь <u>түр болон бүрмөсөн</u> зогсоосон тохиолдолд эзэмшигч нь гэрчилгээг <u>ИНЕГ</u>-т нэн даруй хураалгана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан. -Гэрчилгээний хугацаа “3 жил” гэснийг “5 жил” гэж өөрчлөгдсөн</p>
<p>149.13. Гэрчилгээ сунгах (a) Нисэх клубийн гэрчилгээ сунгуулах хүсэлтийг Нисэх клубийн гэрчилгээ эзэмшигч <u>САА 24149/01</u> маягтаар гаргана. (b) Тухайн хүсэлтийг, гэрчилгээнд заасан сунгах хугацаанд, хэрэв гэрчилгээнд сунгах хугацаа заагаагүй бол, гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө <u>Даргад</u> хүргүүлнэ.</p>	<p>149.13. Гэрчилгээний хугацааг сунгуулах (a) Эзэмшигч нь нисэх клубын гэрчилгээний хугацааг сунгуулах тухай өргөдлийг гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө <u>ИНЕГ-0149/01</u> маягтын дагуу гаргаж <u>ИНЕГ-т</u> ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>В Бүлэг-Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</p>	<p>Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>	
<p>149.51. Ажилтанд тавих шаардлага (a) Нисэх клубийн гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь</u> дараах ажилтныг, үндсэн ажилтнаар эсхүл гэрээгээр ажиллуулна: (1) тухайн байгууллагын бүх үйл ажиллагааг энэ Дүрэмд заасан шаардлагын дагуу гүйцэтгэж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй <u>Гүйцэтгэх захирлаар</u> тодорхойлогдсон удирдах ажилтан; (2) аливаа этгээдэд гэрчилгээ болон зэрэглэл олгох зорилгоор, <u>Даргын шилжүүлсэн эрх</u> эзэмших удирдах ажилтан, эсхүл ажилтнууд; (3) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээх удирдах ажилтан, эсхүл ажилтнууд. Эдгээр удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээнэ; (4) Ерөнхий зааварт заасан ажиллагааг гүйцэтгэх хангалттай тооны ажилтан.</p>	<p>149.51. Ажилтнуудад тавигдах шаардлага (a) <u>Өргөдөл гаргагч</u> дараах албан тушаалтан, ажилтантай байна: 1/ өргөдөл гаргагчийн зүгээс явуулж буй бүх үйл ажиллагаа энэ дүрмээр тогтоогдсон шаардлагын дагуу гүйцэтгэгдэж, санхүүжиж байгааг бататгах эрх бүхий <u>удирдах албан тушаалтан</u>; 2/ <u>ИНЕГ</u>-аас, нисэх спортын зэрэглэл олгох <u>эрх олгогдсон</u> ажилтан (ажилтнууд); 3/ энэ дүрмийн шаардлага мөрдөгдөж байгааг хянах үүргийг удирдах албан тушаалтны өмнө хүлээсэн ажилтан; 4/ Үйл ажиллагааны заавар (цаашид Заавар гэх)-т дурдсан үйл ажиллагааг гүйцэтгэх бусад ажилтнууд.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -гэрчилгээ орхигдсон нь ойлгомжгүй болсон</p>

<p>(b) <u>Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:</u> (1)<u>хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заагдсан ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээсэн ажилтны үр чадварт үнэлгээ хийх,түүнийг хадгалах журмыг тогтоох;</u> (2)<u>удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын эзэмшиж байгаа шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх журмыг тогтоох;</u> (3)<u>энэ Дүрмийн дагуу хариуцлага хүлээсэн ажилтанд үүрэг хариуцлагаа бүрэн хэрэгжүүлэх эрхийг бичгээр олгох.</u></p>	<p>(б) Өргөдөл гаргагч нь өөрийн Зааварт заасан журмыг нарийн чанд мөрдөх үүрэгтэй.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>149.53. Байгууламжийн шаардлага Нисэх клубийн гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч</u> байгууламж болон үйл ажиллагааны нөөцийн хангалт нь хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан ажиллагаанд тохирч байгааг бататгана.</p>	<p>149.53. Хангалт (а) <u>Өргөдөл гаргагч нь</u> Заавартаа тусгагдсан үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэртэй байхын зэрэгцээ нисэх клубын гишүүд, ажилтнуудыг сургах, тэдэнд зааварчилгаа өгөх нөхцөлийг бүрдүүлсэн, мөн техник, тоног төхөөрөмжийг хадгалах, засвар үйлчилгээ хийх зориулалт бүхий ажлын байраар хангагдсан байна.</p>	<p>-<i>Facility requirements</i> хангалт гэснийг <u>байгууламжийн шаардлага</u> болгосон</p>
<p>149.55. Баримт бичиг (а) <u>Нисэх клубийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> Ерөнхий заавартаа заасан ажиллагааны журмыг тогтооход шаардлагатай холбогдох бүх төхөөрөмжийн заавар, техникийн стандарт болон практик аргачлал, техникийн бюллетень, зааварчилгаа, хууль тогтоомж болон бусад баримт бичгийн хувийг ашиглахад бэлэн байлгана. Энэ баримт бичигт удирдах ажилтан болон байгууллагатай холбоотой хүний хүчин зүйлийн материал багтсан байна. (б) <u>Хүсэлт гаргагч нь</u> энэ зүйлийн (а)-д шаардсан холбогдох бүх баримт бичгийг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах журмыг тогтооно.</p>	<p>149.55. Бичиг баримт (а) <u>Өргөдөл гаргагч нь</u> Заавартаа дурдсан үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжийн зааварчилгаа, бюллетень, хүний хүчин зүйлийн талаарх сургалтын материал, бусад бичиг баримтыг бүрдүүлсэн байна. (б) <u>Өргөдөл гаргагч нь</u> энэ зүйлийн (а)-д заасан бичиг баримтыг хянах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах журамтай байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>149.57. Бүртгэл хөтлөх (а)<u>Нисэх клубийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> Ерөнхий заавартаа заасан үйл ажиллагаанд шаардлагатай бүртгэлийг ангилах, бүрдүүлэх, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах журмыг тогтооно. (б)Тухайн журам нь дараах <u>шаардлагыг бататгана:</u> (1)149.63-д заасан журмын дагуу, <u>хүсэлт гаргагчийн байгууллагын</u> дотоод чанар баталгаажуулалтын гүйцэтгэсэн ажиллагаа бүр бүртгэлтэй байх; (2)хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс үйл</p>	<p>149.57. Бүртгэл, тэмдэглэлд тавигдах шаардлага (а) <u>Өргөдөл гаргагч нь</u> Заавартаа дурьдсан үйл ажиллагаанд шаардлагатай тайлан бүртгэл хөтлөх, цуглуулах, дугаарлах, хадгалах журмыг тогтоосон байна. (б) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах бүртгэлийг хөтөлнө: 1/ энэ дүрмийн 149.63-д заасан журмын дагуу гүйцэтгэгдсэн чанарын хяналт, баталгаажуулалтын арга хэмжээний бүртгэл; 2/ Нисэх клубын гишүүд, ажилтнуудын бүртгэл. Энэ бүртгэлд</p>	

<p>ажиллагаа гүйцэтгэх этгээд бүр бүртгэлтэй байх. Тухайн бүртгэлд тэдгээрийн туршлага, мэргэшил, сургалт, ур чадварын үнэлгээний дэлгэрэнгүй мэдээллийг багтаана;</p> <p>(3)тухайн байгууллагаас аливаа этгээдэд олгосон гэрчилгээ болон зэрэглэл бүртгэлтэй байх;</p> <p><u>(4)бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд засварлах боломжгүй байх;</u></p> <p>(5)бүх бүртгэлийг, тухайн бүртгэлд сүүлчийн бичилт хийснээс хойш 3-аас доошгүй жил хадгалдаг байх.</p>	<p>тэдгээрийн туршлага, мэргэшил, сургалт, ур чадварын тухай мэдээллийг оруулсан байна;</p> <p>3/ Нисэх клубээс олгосон нисэх спортын үнэмлэх, зэрэглэлийн бүртгэл.</p> <p>(в) Энэ зүйлийн (б)-д заасан бүртгэлүүдийг цэвэр, гаргацтай хөтлөх ба бүх бүртгэлийг сүүлчийн бичилт хийснээс хойш 3-аас доошгүй жил хадгална.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>149.59. Гэрчилгээжүүлэлт</p> <p>(а)Нисэх клубийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь аливаа этгээдэд гэрчилгээ эсхүл зэрэглэл олгох зорилгоор дараах журмыг тогтооно:</p> <p>(1)дүйцэх мэргэшил эзэмшигчийг багтаасан, аливаа этгээдэд ур чадварын үнэлгээ хийх;</p> <p>(2)хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заагдсан гэрчилгээ болон зэрэглэл олгох;</p> <p>(3)<u>Даргын шилжүүлсэн эрхийн</u> хүрээнд олгогдсон гэрчилгээ, эсхүл зэрэглэл эзэмшиж байгаа этгээдийн ур чадварыг үнэлэх болон хадгалах.</p> <p><u>(b)Энэ зүйлийн (а)-д шаардсан журам нь Хууль болон ИНД-ийн шаардлагыг хангах журмыг багтаасан байна.</u></p>	<p>149.59. Гэрчилгээ, <u>мэргэжлийн зэрэг</u></p> <p>(а) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах журмыг тогтооно:</p> <p>1/ нисэх клубын гишүүд, тэдгээртэй адилтгах мэргэжил бүхий хүмүүсийн мэдлэг, ур чадварыг дүгнэх;</p> <p>2/ өргөдөл гаргагчийн Зааварт дурдсан нисэх спортын гэрчилгээ, зэрэг олгох;</p> <p>3/ нисэх спортын үнэмлэх, зэрэглэл эзэмшигчдийн мэдлэг, ур чадварыг <u>ИНЕГ-аас олгосон эрхийн</u> дагуу дүгнэх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>149.61. Нисэх спортын арга хэмжээ</p> <p>Нисэх спортын арга хэмжээ зохион байгуулах эрхтэй нисэх клубийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоох үүрэгтэй:</p> <p>(1)ИНД-91-ийн нийцлийг бататгах;</p> <p><u>(2)нисэхийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюулыг тодорхойлох болон тухайн эрсдэл нь үнэлэгдсэн бөгөөд зохицуулагдсан болохыг бататгах.</u></p>	<p>149.61. Нисэх спортын арга хэмжээ</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь, Нисэх спортын арга хэмжээний үеэр ИНД-91-ийн шаардлагыг хангах журам боловсруулсан байна.</p>	<p>-Amend.2-оор өөрчлөгдсөн</p>
<p>149.62. Шилжилтийн зохицуулалт</p> <p>(а)Нисэх спортын арга хэмжээ зохион байгуулах эрхтэй нисэх клубийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийг 2020 оны 2 сарын 1 хүртэл 149.61(2)-ыг мөрдөхийг шаардахгүй.</p> <p><u>(b)Энэ зүйл нь 2020 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.</u></p>		<p>-Amend.2-оор нэмэгдсэн</p>
<p>149.63. Дотоод чанар баталгаажуулалт</p> <p>(а)<u>Нисэх клубийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u>, энэ дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлнэ.</p>	<p>149.63. Чанар баталгаажуулалтын дотоод <u>систем</u></p> <p>(а) <u>Өргөдөл гаргагч нь</u> энэ дүрмээр шаардсан журмууд хэрхэн мөрдөгдөж байгаа болон үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэхийг бататгах зорилго бүхий чанар баталгаажуулалтын дотоод системтэй байна.</p>	

<p>(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байна:</p> <p>(1) хүсэлт гаргагчийн байгууллагын зорилго болон түүний гишүүдийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээнд тохирсон аюулгүй байдлын бодлого болон аюулгүй байдлын бодлогын журам;</p> <p>(2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг тогтоох зорилгоор ажилтан болон гишүүдийн санал хүсэлтийг багтаасан чанарын үзүүлэлтэд мониторинг хийдэг болохыг бататгах журам;</p> <p>(3) тухайн тогтолцоонд тогтоогдсон хүндрэлтэй асуудлыг засаж залруулсан болохыг бататгах залруулах арга хэмжээний журам;</p> <p>(4) тухайн тогтолцоонд илэрсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгасан болохыг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;</p> <p>(5) хүсэлт гаргагчийн байгууллага нь аюулгүй байдлын бодлогодоо нийцэж байгаад аудит хийх дотоод аудитын хөтөлбөр;</p> <p>(6) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохирол болон үр дүн нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах удирдлагын дүгнэлт хийх журам.</p> <p>(c) Аюулгүй байдлын бодлогын журам нь аюулгүй байдлын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгодог, хэрэгжүүлдэг болон мөрддөг болохыг бататгана.</p> <p>(d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байна:</p> <p>(1) оршиж байгаа хүндрэлтэй асуудлыг залруулах;</p> <p>(2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор залруулах арга хэмжээг эргэн шалгах;</p> <p>(3) залруулах арга хэмжээний үр дүнд, журамд өөрчлөлт оруулах;</p> <p>(4) удирдах ажилтан залруулах арга хэмжээний үр дүнг дүгнэх.</p> <p>(e) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байна:</p> <p>(1) хүндрэл үүсгэж болох суудлыг залруулах;</p> <p>(2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн шалгах;</p> <p>(3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд,</p>	<p>(б) Чанар баталгаажуулалтын дотоод систем нь дараах журмуудад үндэслэнэ:</p> <p>1/ нисэх клубын зорилго, түүний гишүүдийн хэрэгцээнд чиглэсэн аюулгүй ажиллагааны бодлогыг тодорхойлсон заавар журам;</p> <p>2/ чанарын үзүүлэлтүүдийг хянах, болзошгүй дутагдлыг илрүүлэх, мэдээлэх журам;</p> <p>3/ илэрсэн зөрчлийг арилгах, залруулах арга хэмжээний журам;</p> <p>4/ осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;</p> <p>5/ дотоод хяналтын хөтөлбөр;</p> <p>6/ удирдлагын давхар хяналтын журам.</p> <p>(в) Үйл ажиллагааны заавар журмууд нь ойлгомжтой, нисэх клубын дотоод зохион байгуулалтын бүх түвшинд хэрэгжихүйц байна.</p> <p>(г) Зөрчлийг залруулах арга хэмжээний журам нь дараах зүйлийг тодорхойлно:</p> <p>1/ зөрчлийг хэрхэн арилгах;</p> <p>2/ залруулах арга хэмжээний үр дүнг баталгаажуулах;</p> <p>3/ дутагдлыг арилгах арга хэмжээний үр дүнд холбогдох журмуудад хэрхэн өөрчлөлт хийх талаар;</p> <p>4/ залруулах арга хэмжээ бүрийн үр нөлөөг клубын удирдлагын зүгээс давхар хянах.</p> <p>(д) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах зүйлүүдийг тусгасан байна:</p> <p>1/ үүсэж болзошгүй асуудал/зөрчил/-ыг хэрхэн шийдвэрлэх талаар;</p> <p>2/ урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг баталгаажуулах талаар;</p> <p>3/ урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд холбогдох</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
--	--	-----------------------------------

<p>журамд өөрчлөлт оруулах; (4) удирдах ажилтан урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг дүгнэх.</p> <p>(f) Дотоод <u>аудитын</u> хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) аудит хийгдэх ажиллагааны шинж чанартай уялдуулан аудитын давтамж болон байрлалыг заах;</p> <p><u>(2) аудитыг, тухайн аудит хийгдэж байгаа ажиллагаанд шууд хариуцлага хүлээсэн этгээдээс хамааралгүй, сургалтад хамрагдсан аудитын ажилтан хийдэг болохыг бататгах;</u></p> <p>(3) аудитын үр дүнг, аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтанд болон дотоод аудит хариуцсан менежерт мэдээлдэг болохыг бататгах;</p> <p><u>(4) хэрэв аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол, аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтнаас урьдчилан сэргийлэх эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаардах;</u></p> <p><u>(5) авч хэрэгжүүлсэн залруулах, эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд дүгнэлт хийх зорилгоор эргэн шалгах аудит хийдэг болохыг бататгах.</u></p> <p>(g) Удирдлагын дүгнэлт хийх журам нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг авч үзсэний үндсэн дээр, чанар баталгаажуулалтын тогтолцооны Удирдлагын дүгнэлт хийх давтамжийг тодорхойлох;</p> <p>(2) тухайн чанар баталгаажуулалтын тогтолцоонд дүгнэлт хийх менежерийг тогтоох;</p> <p>(3) дүгнэлтийн үр дүнг дүгнэж, бүртгэдэг болохыг бататгах.</p> <p>(h) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалд нөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх захиралд шууд хандана.</p>	<p>журмуудад хэрхэн өөрчлөлт хийх талаар;</p> <p>4/ урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүрийн үр нөлөөг клубын удирдлагын зүгээс давхар хянах.</p> <p>(е) Дотоод <u>хяналтын</u> хөтөлбөрт дараах зүйлүүдийг тусгасан байна:</p> <p>1/ шалгах үйл ажиллагааны шинж байдлыг харгалзан хяналт тавих объект, давтамжийн талаар;</p> <p>2/ хяналтыг хэн гүйцэтгэх тухай;</p> <p>3/ шалгалтын дүнг хэрхэн мэдээлэх тухай;</p> <p>4/ шалгалтаар дутагдал илэрсэн тохиолдолд түүнийг арилгах арга хэмжээг хэрхэн авах тухай;</p> <p>5/ урьдчилан сэргийлэх буюу зөрчлийг арилгах арга хэмжээний үр нөлөөг дахин шалгах.</p> <p>(ж) Удирдлагын зүгээс давхар шалгах журамд дараах зүйлийг тусгасан байна:</p> <p>1/ чанар баталгаажуулалтын системийн байнгын ажиллагааг хангах үүднээс түүнийг удирдлагын зүгээс давхар шалгах шалгалтын давтамжийг тодорхойлох;</p> <p>2/ чанар баталгаажуулалтын системд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг тодорхойлох;</p> <p>3/ давхар шалгалтын үр дүнг үнэлж, бүртгэх явдлыг хангах.</p> <p>(з) Чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан ажилтан нь аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлаар удирдах албан тушаалтантай шууд харьцах эрхтэй байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>149.65. Нисэх клубийн Ерөнхий заавар</p> <p>(a) Нисэх клубийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах холбогдох журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргад ирүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад журамд дараах шаардлагыг багтаасан болохыг бататган,</p>	<p>149.65. Үйл ажиллагааны заавар</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь дараах зүйлийг тусгасан Нисэх клубын Үйл ажиллагааны зааврыг боловсруулж ИНЕГ-т ирүүлнэ:</p> <p>1/ энэ дүрмийн биелэлтийг хариуцсан, нисэх клубын нэрийн өмнөөс ИНЕГ-тай шууд харьцах эрх бүхий удирдах албан тушаалтнуудын нэрс.</p>	

хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:

(i) тухайн байгууллагыг тодорхойлсон ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулсан байх;

(ii) түүнийг байнга дагаж мөрдөхийг шаарддаг байх;

(2) 149.51(a)(1), (2) болон (3)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын албан тушаал болон нэр;

(3) 149.51(a)(1), (2) болон (3)-т шаардсан, байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах, асуудлыг багтаасан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын үүрэг болон хариуцлага;

(4) 149.51(a)(3)-т заасан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан, энэ зүйлийн (a)(6)-гийн дагуу заасан байрлал бүрийг хамарсан байгууллагын бүтцийн зураг;

(5) тухайн гэрчилгээний хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагааны тодорхойлолт;

(6) үйл ажиллагааг гүйцэтгэх үндсэн байрлал;

(7) 149.53-т шаардсан байгууламжийн тодорхойлолт;

(8) дараах дүрэмд шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл:

(i) 149.51(b)(1) - ажилтны үр чадварын талаар;

(ii) 149.51(b)(2) - удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын эзэмшиж байгаа аливаа шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх талаар;

(iii) 149.55(b) - баримт бичгийн хяналт, нэмэлт өөрчлөлтийн талаар;

(iv) 149.57(a) - бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах талаар;

(v) 149.59(a) - ажилтныг үнэлэх гэрчилгээ болон зэрэглэл олгох, гэрчилгээ, зэрэглэл эзэмшигчийн үр чадварын үнэлгээ хийх болон хадгалах талаар;

(vi) 149.61 - аюулыг таньж тогтоох болон эрсдэлийн удирдлагыг багтаасан нисэх спортын арга хэмжээ зохион байгуулах талаар;

(vii) 149.63 - тухайн байгууллагын дотоод чанар баталгаажуулалтын талаар;

2/ албан тушаалтнуудын буюу ажилтнуудын хүлээх үүрэг;

3/ клубын зохион байгуулалт, бүтцийн зураглал;

4/ гэрчилгээний дагуу явуулах үйл ажиллагааны тодорхойлолт;

5/ үйл ажиллагааг явуулах үндсэн байршил;

6/ энэ дүрмийн 149.53-т заасан нөхцөлийг хангасан байдлын тодорхойлолт;

7/ дор дурдсан журмуудыг нарийвчлан тодорхойлсон байх:

7.1 энэ дүрмийн 149.51-д дурьдсан албан тушаалтан, ажилтнуудын мэргэшил, ур чадварын талаар;

7.2 энэ дүрмийн 149.55-д заасан бичиг баримтын ашиглалтын талаар;

7.3 энэ дүрмийн 149.59-т дурьдсан нисэх клубын гишүүд, тэдгээртэй адилтгах мэргэжил бүхий хүмүүсийн ур чадварыг үнэлэх, нисэх спортын үнэмлэх, зэрэглэл олгох талаар;

7.4 энэ дүрмийн 149.61-т дурьдсан нисэх спортын арга хэмжээг зохион байгуулах талаар;

7.5 энэ дүрмийн 149.63-д дурьдсан чанар баталгаажуулалтын дотоод системийн талаар.

8/ зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт хийх, түгээх журам.

(б) Нисэх клубын Үйл ажиллагааны заавар нь ИНЕГ-аар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

-Орхигдуулсан заалтыг
нэмж оруулсан

<p>(9)Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам. (b)Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.</p>		
<p>С Бүлэг – Үйл ажиллагааны шаардлага</p>	<p>В БҮЛЭГ . ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА</p>	
<p>149.101. Байнгын хэрэгжилт Нисэх клубийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна: (1)байгууллагын Ерөнхий зааврын хүчинтэй нэгээс доошгүй бүрэн хувийг Ерөнхий зааварт заасан үндсэн байрлал бүрд хадгалах; (2)Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журмыг дагаж мөрдөх; (3)Ерөнхий зааврын холбогдох бүлгийг, шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд нь хэрэглэхэд боломжтой байлгах; (4)В Бүлгийн шаардлага болон стандартыг байнга хангах; (5)CAA24149/01 маягтаар шаардсан үйлчилгээний хаяг, утасны дугаар, факсын дугаарын өөрчлөлтийг Даргад шууд мэдэгдэх.</p>	<p>149.101. Үндсэн үүрэг (а) Нисэх клубын гэрчилгээ эзэмшигч нь: 1/ клубын Зааврын хувийг клубын үндсэн байршил бүрт хадгална; 2/ тухайн Зааварт тусгагдсан бүх журмуудыг мөрдөнө; 3/ шаардлагатай гэж үзвэл клубын ажилтан, гишүүдэд Зааврын холбогдох заалтуудыг хувилж түгээсэн байна; 4/ энэ дүрмийн Б бүлэгт заасан шаардлагуудыг байнга дагаж мөрдөнө; 5/ байгууллагын нэр хаяг, харилцах утас, факс, цахим-шуудангийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг ИНЕГ-т ажлын 3 хоногийн дотор ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>149.103. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт (а)Нисэх клубийн гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг тухайн байгууллагын тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийсэн болохыг бататгах үүрэгтэй. (б)Гэрчилгээ эзэмшигч Ерөнхий зааварт оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгаа ба Ерөнхий зааварт агуулагдсан нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу хийсэн болохыг бататгана. (с)Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсан даруйд нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй. (д)Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлт хийхээр санал болгож байгаа бол Даргад урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсан байх шаардлагатай: (1)Гүйцэтгэх захирал; (2)нэр заагдсан удирдах ажилтнууд; (3)Даргын шилжүүлсэн эрх эзэмшигч, эсхүл</p>	<p>149.103. Нисэх клубын Зааварт өөрчлөлт оруулах (а) Гэрчилгээ эзэмшигч нь Үйл ажиллагааны заавартаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа нисэх клубын үндсэн чиг үүрэг, тодорхойлолт хэвээр үлдэнэ гэдгийг бататгана. (б) Зааварт оруулах нэмэлт өөрчлөлт нь энэ дүрмийн шаардлагад нийцсэн байна. (в) Гэрчилгээ эзэмшигч нь Заавартаа оруулах нэмэлт өөрчлөлтийг ИНЕГ-аар хянуулж, баталгаажуулна. (г) Гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд ИНЕГ-ын саналыг авсан байна: 1/ удирдах албан тушаалтныг солих; 2/ энэ дүрмийн 149.51-ийн (а)-гийн 2-т заасан ажилтныг солих; 3/ гэрчилгээгээр зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанд өөрчлөлт</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p> <p>-Орхигдсон заалтыг нөхөн оруулсан</p>

<p>эзэмшигчид; (4)гэрчилгээгээр зөвшөөрсөн ажиллагаа; (5)үйл ажиллагаа явагдах үндсэн байрлал; (6)аливаа этгээдэд үнэлгээ хийх болон гэрчилгээ олгох журам; (7)нисэх спортын арга хэмжээ зохион байгуулах журам.</p> <p><u>(e)Хамааралгүй</u></p> <p>(f) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа тухайн гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх нөхцөлийг <u>Дарга</u> тогтоож болно.</p> <p><u>(g)Гэрчилгээ эзэмшигч, энэ зүйлийн (f)-ийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.</u></p> <p>(h)Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь тухайн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардсан бол, гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг <u>Даргад</u> зохих бичилт хийлгэхээр нэн даруй хүргүүлнэ.</p> <p><u>(i) Дарга нэмэлт өөрчлөлтийг хийх нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзвэл,</u> гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа тухайн нэмэлт өөрчлөлтийг оруулна.</p>	<p>оруулах; 4/ үйл ажиллагаа явуулах байршлаа өөрчлөх; 5/ нисэх клубын гишүүд болон тэдэнтэй адилтгах мэргэжилтэй хүмүүсийг үнэлж дүгнэх, тэдэнд үнэмлэх, зэрэглэл олгох журмыг өөрчлөх; 6/ нисэх спортын арга хэмжээ явуулах журамд өөрчлөлт оруулах.</p> <p>(д) Энэ зүйлийн (г)-д заасан өөрчлөлтийн аль нэгийг хийх хугацаанд гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг <u>ИНЕГ</u>-аас тодорхойлж өгч болно.</p> <p>(е) Энэ зүйлийн (г)-д заагдсан өөрчлөлтийн улмаас гэрчилгээнд өөрчлөлт орохоор бол эзэмшигч нь гэрчилгээг <u>ИНЕГ</u>-т нэн даруй ирүүлнэ.</p> <p>(ж) Гэрчилгээ эзэмшигч нь, <u>ИНЕГ-аас нисэхийн аюулгүй ажиллагааны талаар гаргасан шаардлага, бичиг баримтыг үндэслэн</u> Үйл ажиллагааны заавартаа нэмэлт өөрчлөлтийг тухай бүрд нь хийнэ.</p>	
--	---	--

Дүрмийн боловсруулалтын хэлтэс